

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АРВАЙХЭЭР ЦЭЦЭРЛЭГЖИЛТ
ОНӨААТҮГ-ЫН 2018, 2019
ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР
ДҮН

АУДИТЫН КОД: ӨВА-/2020/06-НА

Арвайхээр хот 2020 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Л.Ламаачин
Утас: 70323253, цахим
хаяг: Lamaanchinl@audit.gov.mn

Аудитын менежер Д.Гансүх, Утас: 70323833,
цахим хаяг: Gansukhd@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Хорлоосүрэн, Утас: 70323108,
цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Аудитор: Ө.Ринчинмядаг, Утас: 70323108,
цахим хаяг: Renchinmyadaqu@audit.gov.mn

Аудитор: Э.Энхбаяр, Утас: 70323108,
цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
Ерөнхий мэдээлэл	3
БҮЛЭГ-1 Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах эрх зүйн орчин бүрдээгүй, Төлөөлөн удирдах зөвлөл хангалтгүй ажилласан байна.	5
1.1. Тухайн байгууллагатай хамааралтай орон нутгаас баримталж буй бодлого хэрэгжиж байна.	5
1.2. Компани нь хууль, дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа бүрэн явуулаагүй, Төлөөлөн удирдах зөвлөл нь чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна.	6
БҮЛЭГ-2 Орлого, зардлын төлөвлөлт үндэслэл муутай, дотоод хяналт хангалтгүй хийгдсэн байна.	8
2.1. Үйл ажиллагааны орлогыг бодитоор төлөвлөөгүй, бүрэн төвлөрүүлэхгүй байна.	8
2.2. Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулахад санаачилгагүй ажилласан байна.	10
2.3. Санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийгдсэн боловч Төлөөлөн удирдах зөвлөлөөс тавих хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.	12
БҮЛЭГ-3 Байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдсан боловч, төлөвлөсөн ажлуудын хэрэгжилт хангалтгүй, тооцоо судалгаагүй ажиллаж байна.	13
3.1. Байгууллагын үйл ажиллагаа нь хэвийн явагдаж, ажлын төлөвлөлт хангалтгүй хэрэгжсэн байна.	13
3.2. Гүйцэтгэх удирдлага гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан боловч хуульд заасан чиг үүргийн хүрээнд ТУЗ нь хэрэгжилтийг дүгнэж ажиллаагүй байна.	14
3.3. Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын хэрэгжилт, үр дүнгийн талаар тайлан, мэдээ, тооцоолол байхгүй байна.	15
ДҮГНЭЛТ	17
ЗӨВЛӨМЖ 1.....	18
ЗӨВЛӨМЖ 2.....	18
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	АЖ АХУЙ НЭГЖ
АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ИТХ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ИТХТ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД
МХГ	МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
НА	НИЙЦЛИЙН АУДИТ
НББ	НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ
ОНӨААТҮГ	ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
ӨВА	ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТБОНӨ	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧ
ТУЗ	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ХАБ	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Ерөнхий мэдээлэл**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудиторт 2020 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Өвөрхангай аймгийн Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын 2018-2019 оны үйл ажиллагааны үр дүнд нийцлийн аудит хийж гүйцэтгэв.

Аудитын зорилтууд:

Өвөрхангай аймгийн Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын 2018-2019 оны үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж буй эсэхэд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлийн хүрээнд аудит хийсэн. Үүнд:

- ❖ Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах эрх зүйн орчин оновчтой эсэх
- ❖ Орлого зардлын төлөвлөлт, гүйцэтгэл оновчтой үр дүнтэй эсэх
- ❖ Байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжтэй байдал, үр дүнтэй эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитаар Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын 2018-2019 оны үйл ажиллагааны үр дүн, орлого зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг оновчтой хэрэгжүүлсэн эсэхэд аудитыг хийж гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл:

Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай” 08 дугаар тогтоолоор Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс байгуулах шийдвэр гаргасан байна.

Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын 2018 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 362.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн, бусад зардалд 132.2 сая төгрөг зарцуулахаар, 2019 онд 518.5 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн байна. 2018, 2019 онд Арвайхээр сумын Хүүхэд залуучуудын паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх, угсрах ажил, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. 2019 оныг Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил болгох ажлын хүрээнд хөрс бэлтгэлийн ажил, мод бут сөөг тарих нүх ухах, зүлэг тарих талбай бэлдэх, зүлэг, цэцэг тарих ажлууд хийгдсэн байна.

Арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 400, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал асуулга авах, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашигласан.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ❖ Төрийн аудитын тухай хууль
- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Компани тухай хууль
- ❖ Захиргааны ерөнхий хууль
- ❖ Татварын ерөнхий хууль
- ❖ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ❖ Нийгмийн даатгалын тухай хууль
- ❖ Хөдөлмөрийн тухай хууль
- ❖ Аймгийн ИТХ-ын тогтоол, ТУЗ-ийн тогтоол, хурлын шийдвэр,
- ❖ Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аудитын менежер Д.Гансүх стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор П.Хорлоосүрэн, аудитор Ө.Ринчинмядаг, Э.Энхбаяр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2020 оны 05 дугаар сарын 07-оос эхлэн, 07 дугаар сарын 10-ны дотор үе шатны хяналтаар оруулж, тайланг баталгаажуулан, орон нутгийн холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэв.

Аудитын явцад үүссэн хүндрэлтэй асуудал:

- 🚧 Аудит хийхэд шаардлагатай баримт материал, нарийн тооцооллууд, тендерийн баримт бичгийг хугацаанд гаргаж өгөөгүйгээс цаг хугацаа алдсан.
- 🚧 Тендерээр хийж гүйцэтгэсэн ажлуудын дэлгэрэнгүй тайлан ялангуяа түүнтэй холбоотой гарсан зардал, ашиг, орлогын тооцооллыг удаа дараа шаардсан боловч материалыг авчирч өгөөгүй.
- 🚧 Санхүүгийн баримт материалын эмх цэгц тааруу, ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, шийдвэр хангалтгүй байна.

Аудитаар 2315.5 мянган төгрөгийн акт, 11057.6 мянган төгрөгийн албан шаардлага өгч, 579800.0 мянган төгрөгийн зөвлөмж өгч, үр өгөөж тооцож хүлээн зөвшөөрүүлсэн.

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВАГДСАН БОЛОВЧ ДОТООД
ХЯНАЛТ ХИЙГДЭЭГҮЙ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ХАНГАЛТГҮЙ
АЖИЛЛАСАН БАЙНА.

БҮЛЭГ-1

Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах эрх зүйн орчин бүрдээгүй, Төлөөлөн удирдах зөвлөл хангалтгүй ажилласан байна.

1.1. Тухайн байгууллагатай хамааралтай орон нутгаас баримталж буй бодлого хэрэгжиж байна.

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020” дунд хугацааны хөгжлийн баримт бичигт аймгийн хөгжилд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхээр зорилтуудыг тодорхойлсон. “Арвайхээр Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ-ын үндсэн үйл ажиллагаатай холбоотой дараах зорилтууд тус баримт бичигт тусгагдсан байна. Үүнд:

- ✚ Ойжуулалт, мод үржүүлгийн мэргэжлийн байгууллага, иргэдийн санал санаачилгыг дэмжиж, ойн нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх;
- ✚ Төв суурин газрын ногоон байгууламжийг газар зохион байгуулалтын төлөвлөлтөд тусгах замаар хэмжээг одоогийн түшингээс 2 дахин нэмэгдүүлэх зорилтууд тусгагдсан байна.

Дээрх зорилтын хүрээнд 2018 онд: Арвайхээр сумын Т.Намнансүрэнгийн гудамжинд 238 ширхэг улиас, П.Гэндэний гудамжинд 112 ширхэг шинэс, 360 ширхэг шар хуайс, 200 ширхэг хайлаас, хүүхэд залуучуудын паркт 640 ширхэг шар хуайс, 800 ширхэг хайлаас, захын зүүн талд шинээр 200 ширхэг улиас модыг тарьсан байна

2019 онд:

- ✚ Нийт 21500 ширхэг 6 төрлийн мод бут тарьж, 20000 м2 талбайг зүлэгжүүлэн, 35000 ширхэг цэцгийн мандал нийтийн эзэмшлийн талбайд тарьж, 6812 төрийн албан хаагч, ХХҮГ-тай хамтран гэрээ байгуулсан 120 гаруй хүн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, мод бутны нүх ухах ажилд оролцсон байна.
- ✚ Шар хуайс, хайлаасыг нөхөн тарилтаар суулган шинээр 53 ширхэг нарс модыг суулгасан байна.

Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 09/04 дүгээр тогтоол, Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/13 дугаар захирамжаар 2019 оныг аймгийн хэмжээнд “Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” жил болгон зарласан байна. Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулах, эрүүл тохилог орчныг бий болгох зорилт тавьж, мод, бут тарих ажилд иргэд, олон нийт, төрийн албан хаагчдын оролцоог хангаж ажилласан байна.

“Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ийн ажлын төлөвлөгөөнд “Арвайхээр Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ-тай холбоотой дараах ажлууд тусгагдсан байна. Үүнд:

- ✚ Нийтийн эзэмшлийн талбайд мод, бут тарих ажлыг зохион байгуулах (төлөвлөсөн гудамж, нийтийн эзэмшлийн талбайд нийт 23000 ш мод бут тарьж ургуулах.)
- ✚ Цэцгийн үрсэлгээ бэлтгэх, цэцгийн мандал тарих (төлөвлөгдсөн талбайд 40000 ш цэцгийн мандал тарих.)

- ✚ Нийтийн эзэмшлийн талбайг зүлэгжүүлэх (төлөвлөгдсөн 2 га газарт зүлэг тарьж ургуулах.)
- ✚ Ойгоос мод шилжүүлэн суулгах журмын дагуу төв суурин газарт мод шилжүүлэн суулгах ажлыг зохион байгуулах (нийтийн эзэмшлийн талбайд 100 ш мод шилжүүлэн суулгах.)
- ✚ Дэлгэрэх голын дагуу цэцэрлэгт хүрээлэн байгуулах (Хунбобса цэцэрлэгт хүрээлэн байгуулах.)
- ✚ Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид арчилгаа, усалгаа хийх, харуул хамгаалалтыг сайжруулах (ногоон байгууламжид тарьсан мод бутны амьдралын хувийг 80-с дээш хувиас дээш байлгах.)

“Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ийн ажлын төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлуудын хэрэгжилтийг авч үзвэл:

- ✚ Долоон төрлийн 24469 ш мод тарьсан ба ургалтын явц 2019 оны жилийн эцсийн байдлаар 84 хувьтай байсан.
- ✚ Нийтийн эзэмшлийн зам талбайд 12 цэцгийн мандалд 3 төрлийн 35000 ширхэг үрсэлгээ тарьж ургуулсан.
- ✚ Арвайхээр суманд “Арвайхээр Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ-аас нийтийн эзэмшлийн 20000 м² талбайд олон наст хуйлдаг зүлэг тарих ажлын талбайн хөрсийг бэлтгэхэд 76.0 сая төгрөгөөр хар шороо бэлтгэсэн боловч ажил үр дүнгүй болсон байна.
- ✚ Нийтийн эзэмшлийн талбайд 500 ш шинэс мод Бат-Өлзий сумын ойгоос шилжүүлэн суулгасан.
- ✚ Хунбобса цэцэрлэгт хүрээлэнд нийт 5567 ширхэг улиас мод тарьснаас 2019 оны жилийн эцсийн байдлаар 5215 ширхэг мод ургаж, 352 ширхэг мод ургаагүй бөгөөд ургалт нь 93.6 хувьтай байна.

Зураг-1 Дэлгэрэх голын төгөлд тарьсан модны ургалтын байдал



Зураг-2 Хунбобса цэцэрлэгт хүрээлэнд тарьсан модны ургалтын байдал



1.2. Компани нь хууль, дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа бүрэн явуулаагүй, Төлөөлөн удирдах зөвлөл нь чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухайн хууль, Компанийн тухай хууль, Төсвийн тухай хууль, бусад холбогдох хууль зэргийг мөрдлөг болгон ажиллахаар дүрэмд заасан байна. Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж ажиллаагүйгээс санхүүгийн үйл ажиллагаа хангалтгүй явагдаж ирсэн байна.

Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай” тогтоолоор Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс байгуулах шийдвэр гаргасан байна. Арвайхээр сумын ИТХТ-ийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор Удирдах зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Дүрэмд зааснаар Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ыг эрх барих байгууллага нь Удирдах зөвлөл бөгөөд тухайн байгууллагын жилийн ажлын болон хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн батална гэж заасан байна.

Мөн дүрэмд зааснаас тус газрын гүйцэтгэх захирал нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хангуулах үүрэгтэй гэсэн боловч бизнес төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

“Арвайхээр Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ нь орон нутгийн өмчийн өөрийн баланст бүртгэгдсэн эд хөрөнгө, дүрмээр хүлээсэн эрх үүргийн хүрээнд улс, орон нутгийн төсвөөс олгогдсон хөрөнгө оруулалтаар болон бусад үйл ажиллагааны орлогоор санхүүжих замаар Арвайхээр хотын ногоон байгууламжтай холбоотой бүх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэж тус дүрэмд заасан байна.

“Арвайхээр Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ нь Арвайхээр хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг олон улсын чанар стандартын дагуу хариуцан гүйцэтгэж, эдэлбэр газрын ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар эрүүл, ногоон ухаалаг хотыг бий болгох зорилгоор дүрэмдээ дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнд:

- ✚ Хот цэцэрлэгжүүлэлтийн цогц үйлчилгээ /мод бут тарилт, усалгаа арчилгаа, таналт тайралт/
- ✚ Цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн паркийн ашиглалт хамгаалалт
- ✚ Мод үржүүлэг, үр, тарьц, суулгацын үйлдвэрлэл, худалдаа
- ✚ Байгууллага аж ахуйн нэгжийн гадна талбайн тохижилт, ногоон байгууламжийн ажил үйлчилгээ
- ✚ Био-ялзмагийн бордооны үйлдвэрлэл
- ✚ Өвлийн хүлэмжийн аж ахуй /олон наст болон нэг наст цэцгийн үр үрсэлгээ үйлдвэрлэл/

Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ нь 2018 онд үндсэн чиг үүргийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- ✚ 3, 7, 8 дугаар саруудад нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн мод бутыг тэгшлэн тайрч, залуужуулах болон цэвэрлэгээний огтлолыг хийж будаж, шохойдох ажлыг бүрэн хийж дуусгасан.
- ✚ Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган тооцоо хийж холбогдох газар, ААН-дэд хүргүүлэн ажилсан байна.
- ✚ Аж ахуй нэгж байгууллагатай хамтран мод бут тарих ажлыг зохион байгуулсан. Үүнд: Мөнгөн өргөө ХХК хүүхэд залуучуудын паркт 50ш улиас, БОЭТ-ийн гадна талбайд 50ш улиас, Онги тааз голын сав газрын захиргаа 360м² талбайг зүлэгжүүлэн мод тарьж, фантам байгуулан тохижуулж хүлээлгэн өгсөн.
- ✚ Нийтийн эзэмшлийн талбайн 10 объектод 06 дугаар сарын 03-аас 25-ны хооронд 13 өнгийн 4 төрлийн 30000 гаруй мянган ширхэг цэцгийг үрслүүлэн мандалд

суулгасан.Хүүхэд залуучуудын парк нийт 10 тоглоомтой үүнээс байнгын засвар арчилгаа шаарддаг 8 тоглоом байдаг ба сүүлийн 3 жил ашиглалгүй 1 тоглоом байсныг энэ оны 7 сард ашиглалтад оруулж хэвийн ажиллаж байна. Шинээр гулсуур болон алсыг харагч тоглоомууд шинээр суурилуулсан.

Дараах ажлуудыг 2019 онд хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- ✚ Хотын ногоон байгууламжийг арчлах ургуулах, хөтөлбөрийн хүрээнд:
 - Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг хортон шавжаас сэргийлэх, хортон шавж үүрлэсэн мод бутыг цэвэрлэж, ариутгах, од бутны хэлбэржүүлэх тайралт хийх ажлуудыг 2019 онд жилд 2 удаа буюу 3, 8 дугаар саруудад зохион байгуулсан,
- ✚ Нийт давхардсан тоогоор 6812 хүн ногоон байгууламж, мод бутны нүх ухах ажилд оролцсон бөгөөд төрийн албан хаагчид, тус байгууллагын ажилчид, Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай гэрээ байгуулан зуны хугацаанд 120 гаруй хүмүүс ажиллуулсан байна.
 - Нийт 21500 ширхэг 6 төрлийн мод бут тарьж, 20000м² талбайг зүлэгжүүлэн, 35000 ширхэг мандлын цэцгийн нийтийн эзэмшлийн талбайд тарьж суулгасан.
- ✚ Хүүхэд залуучуудын парк, соёл амралтын хүрээлэнгийн хэвийн үйл ажиллагааг бүрэн ханган ажиллах ажлын хүрээнд:
 - Шинээр суурилуулсан алсыг харагчийн суурийн ажлыг бүрэн хийж дуусгасан бөгөөд гэрэлтүүлгийн ажлыг хийж, цахилгааны асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.
 - Тоглоомуудын засварын ажил жил бүрийн эхээр хийгдэж ирсэн.
 - Хүүхэд залуучуудын парк, Соёл амралтын хүрээлэнд шар хуайс, хайлаасыг нөхөн тарилтаар суулган шинээр 53 ширхэг нарс модыг суулгаж, усалгаа арчилгааг хийж байна.

Дүрэмд заасан чиг үүргийн хүрээнд био-ялзмагийн бордооны үйлдвэрлэл, өвлийн хүлэмжийн аж ахуй /олон наст болон нэг наст цэцгийн үр үрсэлгээ үйлдвэрлэл/ байгуулах ажлууд хийгдээгүй байна.

БҮЛЭГ-2

Орлого, зардлын төлөвлөлт үндэслэл муутай, дотоод хяналт хангалтгүй хийгдсэн байна.

2.1. Үйл ажиллагааны орлогыг бодитоор төлөвлөөгүй, бүрэн төвлөрүүлэхгүй байна.

Тус байгууллагын дүрэмд төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний хөлс, үнэ тарифыг сумын ИТХ-аар батлуулах бөгөөд тус байгууллагын орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ гэж заасан байна. Үүнд:

1. Улс, аймаг орон нутгийн төсвийн санхүүжилт
2. Ажил үйлчилгээнээс олсон бүх орлого
3. Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр

Үйл ажиллагааны орлого 2018 онд паркийн тоглоомын орлого 32400.0 мянган төгрөгийн өөрийн орлого бүрдүүлэх төлөвлөгөөтэй байснаас хүүхдийн паркийн тоглоомын орлогоос 23731.7 мянган төгрөгийг төвлөрүүлж орлого 8668.3 мянган төгрөгөөр тасарсан байна.

Орлого тасарсан гол шалтгаан нь аймгийн МХГ-аас доорх тоглоомуудыг ажиллах боломжгүй гэсэн дүгнэлт гарсантай холбоотой байна.

Хүснэгт-1 Аймгийн МХГ-с ажиллуулах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан тоглоомууд

№	Тоглоомын нэр	Ашиглалтад орсон огноо	Ашиглалтын хугацаа	Анхны өртөг /мян.төг/	Ашиглах боломжгүй дүгнэлт гарсан огноо
1	Гинжит савлуур	2011.12.01	10	67500.0	2018
2	Алсыг харагч /жижиг/	2011.12.01	10	230600.0	
3	Эргэдэг тоглоом 360	2015.10.01	10	196000.0	
Нийт дүн				494100.0	

Сагсан бөмбөг, хөл бөмбөг, гадаа талбайн түрээсийн тарифыг ТУЗ-өөр батлуулаагүй байна.


Арвайхээр-Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын удирдах зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор 2019 оны төсвийг баталсан. Тус тогтоолоор үндсэн үйл ажиллагааны орлого 32400.0 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 7000.0 мянган төгрөгөөр баталсан боловч орлогын төрөл тус бүрээр баталж өгөөгүй байна.

2019 оны гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 41588.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 487.6 мянган төгрөг орсон байна.

Үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 64037.0 мянган төгрөг орж 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар тогтоолоор тодотгож үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Үйл ажиллагааны орлогыг төрөл тус бүрээр нь ямар үзүүлэлтэд үндэслэн төлөвлөснөө ТУЗ-өөр батлуулсан шийдвэр байхгүй, өөрийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр санаачилгагүй ажилласан байна.

Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын ТУЗ-ийн шийдвэрээр баталсан 2018, 2019 оны орлогын эх үүсвэрийн гүйцэтгэлийг харьцуулж үзэхэд:



Дээрх харьцуулалтаас харахад төсвөөс авсан санхүүжилт нь 2019 онд өмнөх оноос 97664.9 мянган төгрөг буюу 92 хувиар нэмэгдсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн

өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дэх заалтыг хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.¹

Байгууллагын хэтийн зорилго, зорилтоо тодорхойлсон бизнес төлөвлөгөөг боловсруулж, ашиг орлогоо тооцоолон ажиллаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21².21³, 24.1⁴ дэх заалтуудыг зөрчсөн байна.

2.2. Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулахад санаачилгагүй ажилласан байна.

2018 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 362000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн, байгууллагын үйл ажиллагаанд 117871.0 мянган төгрөг зарцуулсан байна..

2018-2019 онуудад тус газрын удирдлагаас үндсэн үйл ажиллагааны салбарын үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг бууруулах талаар санаачилга муутай ажилласан байна.

Тус үйлдвэрийн газрын 2018, 2019 оны зардлын гүйцэтгэлийг авч үзвэл:

Хүснэгт-2 Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын 2018, 2019 оны зардлын гүйцэтгэл			
Үзүүлэлтүүд	Зардлын гүйцэтгэл /мян.төг/		Өсөлт
	2018 он	2019 он	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	91351.9	164498.1	73146.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13399.9	24705.8	11305.9
Байр ашиглалттай холбоотой зардал	2777.9	6203.9	3426
Хангамж бараа материалын зардал	3239.9	44282.5	41042.6
Норматив зардал	5735.4		
Эд хогшил, урсгал засварын зардал	647	19862.1	19215.1
Дотоод албан томилолт	160	518	358
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	558.8	811.7	252.9
Бараа үйлчилгээний бусад зардал	25147.1	114480.2	89333.1
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		7352.1	7352.1
Зардлын дүн	143017.9	382714.4	245431.9

Дээрх хүснэгтээс харахад зардлын гүйцэтгэл нь өмнөх оноос 245431.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Цаашид “Арвайхээр Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ нь санхүү, төсвийн хэтийн болон жилийн төлөвлөгөөг боловсруулан мөрдөж, үйл ажиллагааны чиглэл бүрээр орлого, зарлагыг бодитоор тооцоолж, орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн дайчлах, бүртгэл

¹ Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.

² үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;

³ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид “зорилтын санал” гэх/-ын төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. 4


⁴ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;

санхүүгийн ажилтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлж ажилласнаар байгууллагын үр ашгийг дээшлүүлэх боломж байна.

Мод үржүүлэг, үр, тарьц, суулгацаар 2018 онд:

- Нийтийн эзэмшлийн зам талбайд цэцгийн мандал суулгах ажлыг нийт 3360.0 мянган төгрөгөөр хийсэн.
- Хар шороо татах ажилд 3500.0 мянган төгрөг зарцуулсан.
- Арвайхээр сумын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр 9650.0 мянган төгрөгөөр зүлэгжүүлэх, цэцэг тарих ажил хийгдсэн байна.

График-2 2018, 2019 оны мөнгөн хөрөнгө, авлага, өглөгийн үлдэгдэл /мян.төг/



2019 онд мөнгөн хөрөнгө болон авлага нийт 79004.8 мянган төгрөгийн, өглөг 6336.05 төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Төсвийн зарцуулалттай холбоотой 2018, 2019 онд дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

- Гүйцэтгэх захирал Д.Мягмарт 2019 оны 12 сард 1804.3 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг олгохоор тооцох байсныг буруу тооцоолж цалинтай давхардуулан 3896.4 мянган төгрөгийг олгохоор тооцоолж 2092.1 мянган төгрөгийг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1⁵-д заасныг зөрчсөн байна.
- Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллага, аж ахуйн нэгж хандив өргөх асуудал хуулиар хориотой байтал дээд шатны төсвийн захирагч Арвайхээр сумын санхүүчдийн баярын арга хэмжээний зардалд 500.0 төгрөгийн хандив өгсөн.
- Сэлбэгийн үнэнд 1000.0 мянган төгрөгийг 2019 оны 10 сарын 08 өдөр Д.Мягмарын дансанд анхан шатны баримтгүй шилжүүлсэн боловч 2019 оны 10 сарын 23 өдөр буцаан дансанд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.2⁶ дахь заалтыг зөрчсөн байна.

⁵ Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна.

⁶ Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

- Гүйцэтгэх захирлын 2019 оны 12 сард а/108 тоот тушаалаар тус газрын ажилчдад 3230.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгоходоо 839.8 мянган төгрөгийн, 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/09 дүгээр захирлын тушаалаар үр дүнгийн урамшуулал 5675.9 мянган төгрөг олгоходоо 1475.7 мянган төгрөгийн, нийт 2315.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй зөрчлүүд гарсан байна.

Худалдаж авсан үндсэн хөрөнгө, бараа материалыг тухай бүр данс бүртгэлд тусган орлогод авч, зохих журмын дагуу зарлага гарган ажилласан байна.

Төсвийн ил тод байдлыг хангах талаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

- Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар 1,2,3,4-р улирлуудад мэдээлээгүй.
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг дутуу мэдээлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4⁷ дэх хэсэгт заасны дагуу цаашид өмч хамгаалах зөвлөл байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

2.3. Санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийгдсэн боловч Төлөөлөн удирдах зөвлөлөөс тавих хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

Байгууллагын дүрэмд үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг захирал батална. Жил бүр санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт гаргуулж байна гэж заасан.

Байгууллагын захирлын тушаалаар Дотоод хяналтын нэгж байгуулан "Байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" боловсруулсан боловч хяналт хангалттай хийгдээгүй байна.

Байгууллагын 2018, 2019 оны санхүүгийн тайланд "Дөлгөөн хайрхан уул" аудит ХХК аудит хийж баталгаажуулахад:

- ✚ Анхан шатны баримт бүрдэл дутуу, хөрөнгийн тооллого хийж тооцоо бодсон актыг үйлдээгүй, цалингийн урьдчилгаа суутган тооцоогүй, авлагад бүртгээгүй, эзэмшлийн газрын гэрчилгээг авсан боловч газраа үнэлж орлого аваагүй, НББ-ын бодлогын баримт бичиггүй, шатахууны зардлын тайланг гаргахдаа жолоочийн тооцоог бодохгүйгээр зөвхөн шатахууны тайлан гаргасан зөрчлүүд гарсан байна.

ТБОНӨ-ийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4⁸-д заасны дагуу Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ✚ Ажлын үр дүнгээр цалинжуулдаггүй, ажил дүгнэх үзүүлэлтэд өөрийн орлогыг нэмэгдүүлэхэд гаргасан хувь нэмрийн талаар тусгаж өгөөгүй, орон тоо хүрэлцэхгүйн улмаас амралтын өдрүүдээр ажиллуулдаг.

⁷ Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасан өмч хамгаалах Байнгын зөвлөлийг үндсэн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, эсхүл түүний үүрэг биелүүлдэг менежерээр толгойлуулж ерөнхий ня-бо, технологич зэрэг мэргэжлийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр захирлын шийдвэрээр байгуулна.

⁸ холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;

- ✚ Удирдлага, нягтлан бодогч санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх арга хэмжээ авдаггүй, санхүүгийн тайланг төсөвт байгууллагын маягтаар гаргадаг, борлуулалтын өртөг тооцдоггүй.
- ✚ ТУЗ нь санхүүгийн тайланд дүгнэлт хийж, хэлэлцдэггүй, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэл, явцад хяналт тавьж ажилладаггүй. Жилийн эцэст нэг удаа хуралдан үйл ажиллагааг дүгнэж, захирлыг шагнасан.
- ✚ 2013 онд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор үйлчилгээний жагсаалтыг баталж, өөрчлөлт оруулах талаар судалгаа тооцоолол хийгдээгүй байна. Хотын ногоон байгууламжийн тухай хууль байхгүй, хууль эрх зүйн орчин бүрдээгүйн улмаас норм норматив тогтоогдоогүй байжээ.

ТБОНӨ-ийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1⁹, 67.2¹⁰, НББ-ийн тухай хуулийн 19.1¹¹, 20 дугаар зүйлийн 20.2.6¹²-д зааснаар байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллахаар хуульчлагдсан байдаг. Гэтэл аудитын дүгнэлтээс харахад үйл ажиллагааны чиглэл бүрээр орлого, зарлагыг төлөвлөж, тооцдоггүй, нярав, тасалбар түгээгч нарын тооцоог тухай бүр бодож, баталгаажуулаагүй байна.

Дээрх байдал нь тус байгууллагын удирдлага, бүртгэл тооцооны ажилтнууд хуульд заасан үүргээ хангалтгүй биелүүлж, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан гэж үзэж байна. Цаашид дотоод хяналтын бодлого боловсруулж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Компанийн тухай хуулийн дагуу компанийн үйл ажиллагааг удирдах, хяналт тавих үүрэг бүхий 7 хүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөл ажиллаж, жил бүрийн үйл ажиллагааны орлого, зардлын төсөв батлах, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж холбогдох шийдвэр гарган, тодорхой чиглэл өгч ажиллах ёстой.

Гэвч ТУЗ-өөс санхүү болон байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

БҮЛЭГ-3

Байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдсан боловч, төлөвлөсөн ажлуудын хэрэгжилт хангалтгүй, тооцоо судалгаагүй ажиллаж байна.

3.1. Байгууллагын үйл ажиллагаа нь хэвийн явагдаж, ажлын төлөвлөлт хангалтгүй хэрэгжсэн байна.

Аймгийн Цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн паркийн ашиглалт хамгаалалтын ажил 2018, 2019 онуудад хэвийн явагдаж ирсэн байна.

Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ нь 2018 онд үндсэн чиг үүргийн хүрээнд дараах ажлууд хангалтгүй хийгдсэн байна. Үүнд:

⁹ Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.

¹⁰ Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.

¹¹ Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно.

¹² Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

- ✚ Арвайхээр палас зочид буудлын урд 1950 м² талбайд олон наст зүлэгжүүлэлтийн ажил хийгдсэн боловч ургалт нь 1 жилийн насжилттай дахин ургах боломжгүй байна.
- ✚ Наадмын талбайд өвлийн хүлэмж барихаар 38748.5 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч хүлэмж барих газрыг аймгаас шийдэж өгөөгүй тул уг ажил хийгдээгүй байна. Өвлийн хүлэмж байхгүйгээс хувь хүний өвлийн хүлэмжийг түрээсэлж байна.

Гүйцэтгэх захирал нь орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьд ажлын явц, үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж үүрэг чиглэл авч ажиллаагүй нь ТУЗ-ийн үйл ажиллагаа хангалтгүйтэй холбоотой байна.

Тус үйлдвэрийн газар нь 2019 онд доорх ажлуудыг хийсэн байна.

- Аймгийн төвд 2 га талбайг зүлэгжүүлсэн
- Нийт 7.3 га талбайд шинээр ногоон байгууламж байгуулсан
- Гудамж талбайд 35000 цэцэг тариалсан
- Хуучин тариалсан байсан 35.5 га талбайн ногоон байгууламжийг арчилсан байна.

Зураг-3 Наадмын талбайн олон наст хуйлдаг зүлэг тарьсан талбайд зэрлэг ургамал ургасан байна.



Зураг-4 Хэлмэгдэгсдийн хөшөөтэй хэсэгт тарьж ургуулсан олон наст хуйлдаг зүлэг тарьсан боловч ургалтгүй байна.



Гэвч 2 га талбайг зүлэгжүүлэх ажил /2,7 дугаар багийн тоглоомын талбай, хэлмэгсдийн хөшөөтэй хэсэг/ хийхэд Свебау Хаус ХХК зүлэгжүүлэх ажлын тендерийг 98680.6 мянган төгрөгөөр авч олон наст зүлгийн үр нийлүүлэх байсан боловч уг зүлэг нь нэг жил ургаад дахин ургаагүй байна. Уг зүлэгжүүлэлтийн ажлын хар шороо бэлтгэх ажлыг тус газар нь 76000.0 мянган төгрөгөөр хийсэн боловч үр дүнгээ өгөөгүй байна.

Тус байгууллага нь ажилчдаа ХАБ сургалтад хамруулж сертификат олгож аюулгүй ажиллагааны зааварчилгаа тогтмол өгч ажиллаж ирсэн байна.

Аудитын явцад тус газрын 2018, 2019 оны ТУЗ болон гүйцэтгэх удирдлагаас үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлж баталсан хурлын тэмдэглэл, ажлын тайлан, мэдээ, тооцоо судалгааг шаардсан боловч ТУЗ-ыг байгуулсан тогтоолоос өөр материал ирүүлээгүй.

3.2. Гүйцэтгэх удирдлага гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан боловч хуульд заасан чиг үүргийн хүрээнд ТУЗ нь хэрэгжилтийг дүгнэж ажиллаагүй байна.

Тус газрын дүрмийн 6.4-д заасныг үндэслэн гүйцэтгэх захирлын 2018 оны ажлыг ТУЗ-ийн 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 03 тоот тогтоолоор 94.5 хувь буюу “А” үнэлгээтэй дүгнэсэн, 2019 оны ажлыг ТУЗ-ийн 2019 оны 08 дугаар тогтоолоор 99.2 хувь буюу “А” үнэлгээтэй дүгнэсэн шийдвэрийг гаргасан боловч гүйцэтгэх захирал нь сумын Засаг дарга бөгөөд хотын захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг гэрээнд тусгасан хугацаанд албан ёсоор дүгнээгүй байна.

Гүйцэтгэх захирлын 2018, 2019 оны үр дүнгийн гэрээг дүгнээгүй байхад ТУЗ-ийн шийдвэрээр нийт 1540.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

2018 онд тус газрын 13 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж жилийн эцэст 11 үзүүлэлтээр ажилчдын үр дүнгийн гэрээг 85.0-96.5 хувийн хооронд дүгнэсэн, 2019 онд тус газрын 23 ажилтны хөдөлмөрийн гэрээг 73.3-94.3 хувиар дүгнэж 5675.9 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дугаар зүйлд зааснаар тус газрын захирал нь дараах үүргүүдийг гэрээнд тусгаж ТУЗ нь хэрэгжилтийг нь дүгнэж ажиллах үүрэгтэй байна.Үүнд:

1. энэ хуульд заасан эрх, үүрэг;
2. эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин;
3. техник, технологийг шинэчлэх даалгавар;
4. хамт олны хөдөлмөр хамгаалал, нийгмийн талаар авах арга хэмжээ;
5. менежментийн бодлого;
6. захирлаас болон үүргээ биелүүлэх талаар төрөөс хүлээх үүрэг;
7. удирдаж байгаа үйлдвэрийн газарт нь өмчлөгчөөс олгосон эд хөрөнгө, түүний хэмжээ;
8. цалин, нэмэгдэл хөлс, энэ хуульд заасан урамшуулал;
9. ажлын нөхцөл /унаа, холбоо зэрэг/;
10. энэ хуульд заасан эд хөрөнгийн хариуцлага;
11. гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх журам, хугацаа;

Гүйцэтгэх захирал нь гэрээнд дээрх үүргийг нэг бүрчлэн тусгаж, биелэлтийг тооцож, ТУЗ нь дүгнэж ажиллах тал дээр хангалтгүй ажилласан байна.

Арвайхээр сумын засаг дарга бөгөөд хотын захирагчтай 2018 онд 3 бүлэг 4 зорилтын хүрээнд 13 ажил, 2019 онд хийсэн үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 5 бүлэг 5 зорилтын хүрээнд 15 ажил хийхээр төлөвлөж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан байна. Гэвч гэрээний биелэлтийг авч үзэхэд дараах ажлууд гэрээнд заасны дагуу хийгдээгүй байна:

- ✚ Өөрийн орлогын төлөвлөгөөний хуваарийг гарган батлуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй.
- ✚ 2019 онд төсвийн зарцуулалтад тавих хяналт сул байснаас жилийн эцсийн байдлаар өр, авлага үүсэж, ашиг, алдагдлыг нарийн тооцож ажиллаагүй байна.

3.3. Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын хэрэгжилт, үр дүнгийн талаар тайлан, мэдээ, тооцоолол байхгүй байна.

Тайлант онуудын худалдан авах ажиллагааг төлөвлөөгүй, ажил үйлчилгээний тайлан гаргаж ажиллаагүй байна.

Хөрөнгө оруулалтаар дараах ажлууд хийгдсэн байна.

2018 оны хөрөнгө оруулалтаар Арвайхээр сумын хүүхэд залуучуудын паркийн тоглоом шинэчлэлийн ажил хийгдэж 300000.0 мянган төгрөгөөр хүүхдийн тоглоом суурилуулсан.

Арвайхээр сумын хүүхдийн паркийн тоглоомын шинэчлэлийн ажлын гэрээг 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр аймгийн Засаг даргаар батлуулан Захиалагч болох аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Г.Баясгалан, гүйцэтгэгч “Өвөрхангай Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал Ж.Мягмар нар гэрээ байгуулсан байна.

Хүүхэд залуучуудын паркийн Алсыг харагчийн суурийн ажлыг “Гүн чимэгтэй” ХХК-аар 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 20-нд 33573.0 мянган төгрөгөөр хийж комисс хүлээн авсан байна.

Гэвч алсыг харагч тоглоом хөрөнгө оруулалтаар хийгдсэн боловч суурилуулалтын ажил дээр хятад мэргэжилтэн ирж ажилласан ажлын хөлсийг 2019 онд төсөвлөсөн зардлаас илүү 7424.7 мянган төгрөг олгосон нь гэрээний үнийн дүнгээс илүү зардал гарсан байна.

Тус байгууллага нь 2019 онд дараах тендерийн ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- ✚ Арвайхээр сумын нийтийн эзэмшлийн талбайд олон наст хуйлдаг зүлэг тарих, талбайн хөрс бэлтгэх ажилд 76000.0 мянган төгрөгийн хар шороо дэвсэж тухайн зүлэгжүүлэлтийн ажил нь үр дүнгүй болсон байна.
- ✚ Дэлгэрэх голын төгөл ажлын хүрээнд Арвайхээр сумын ЗДТГ-аас “Арвайхээр хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцож 25000.0 төгрөгийн гэрээний дүнтэй ажлыг гүйцэтгэж хайлаас 5000 ширхэг, улиас 1200 ширхэг мод тарьж ургуулан, цэцэг зөөвөрлөх бага оврын ачааны авто машин /портер/ гэрээний дагуу нийлүүлсэн байна.
- ✚ Зам цэвэрлэгээний машин нийлүүлэх 85000.0 мянган төгрөгийн үнэтэй тендерт оролцож Арвайхээр сумын Тохижилт үйлчилгээний компанид нийлүүлсэн байна.

Дээрх тендерүүдийн худалдан авах ажиллагаанд оролцож бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн боловч тус үйлдвэрийн газар нь ашиг, орлогоо тооцож ажиллахгүй байна. Иймд цаашид төсвийн хяналтаа сайжруулах талаар анхаарч, үр дүнг ТУЗ-өөр хэлэлцүүлж ашиг, орлогоо тооцож, төлөвлөгөө гарган ажиллах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

БҮЛЭГ-1 Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах эрх зүйн орчин бүрдээгүй, Төлөөлөн удирдах зөвлөл хангалтгүй ажилласан байна.

1.1. Тухайн байгууллагатай хамааралтай орон нутгаас баримталж буй бодлого хэрэгжиж байна.

1.2. Компани нь хууль, дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа бүрэн явуулаагүй, Төлөөлөн удирдах зөвлөл нь чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна.

БҮЛЭГ-2 Орлого, зардлын төлөвлөлт үндэслэл муутай, дотоод хяналт хангалтгүй хийгдсэн байна.

2.1. Үйл ажиллагааны орлогыг бодитоор төлөвлөөгүй, бүрэн төвлөрүүлэхгүй байна.

2.2. Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулахад санаачилгагүй ажилласан байна.

2.3. Санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийгдсэн боловч Төлөөлөн удирдах зөвлөлөөс тавих хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

БҮЛЭГ-3 Байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдсан боловч, төлөвлөсөн ажлуудын хэрэгжилт хангалтгүй, тооцоо судалгаагүй ажиллаж байна.

3.1. Байгууллагын үйл ажиллагаа нь хэвийн явагдаж, ажлын төлөвлөлт хангалтгүй хэрэгжсэн байна.

3.2. Гүйцэтгэх удирдлага гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан боловч хуульд заасан чиг үүргийн хүрээнд ТУЗ нь хэрэгжилтийг дүгнэж ажиллаагүй байна.

3.3. Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын хэрэгжилт, үр дүнгийн талаар тайлан, мэдээ, тооцоолол байхгүй байна.

ЗӨВЛӨМЖ 1**Арвайхээр Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлд:**

1. Орлого, зарлагын төсвийн төлөвлөлтийг төрөл тус бүрээр нь бодитой тооцон баталж, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллах.
2. Хөрөнгийн үр өгөөжийг тооцож төлөвлөж байх
3. Тухайн жилийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын төлөвлөгөөг батлан, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах
4. Захиралтай байгуулсан гэрээг хууль дүрэмд заасны дагуу ажил үйлчилгээ тус бүрээр төлөвлөн биелэлтийг дүгнэн үр дүнг тооцож ажиллах.
5. Сагсан бөмбөг, хөл бөмбөг, гадаа талбайн түрээсийн тарифыг батлах.

ЗӨВЛӨМЖ 2**“Арвайхээр Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал Д.Мягмарт:**

1. Үйлдвэрийн газрын хэтийн зорилго, зорилтыг тодорхойлсон бизнес төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг сайжруулах.
2. Байгууллагын төсвийг үндэслэлтэй төлөвлөж, орлого, зарлагын гүйцэтгэлд санхүүгийн шинжилгээ хийж, орлого нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх нөөц боломжийг судалж, хэрэгжүүлж ажиллах.
3. Арвайхээр суманд нийтийн эзэмшлийн 2 га талбайд зүлэгжүүлэлтийн хөрс бэлтгэхэд 76000.0 мянган төгрөг зарцуулж хар шороо дэвссэн боловч үр дүнгүй ажил болсон тул нөхөн зүлэгжүүлэлт хийх .
4. Хөрөнгө оруулалтаар хийгдсэн паркийн тоглоомууд нь ашиглалтын хугацаа дуусаагүй байхад МХГ-ын дүгнэлтээр ажиллах боломжгүй болж 494100.0 мянган төгрөгийн үр ашиггүй хөрөнгө бий болгож байгааг цаашид анхаарч төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж байх.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР ЦЭЦЭРЛЭГЖИЛТ
ОНӨААТҮГАЗАР**

62173 Арвайхээр сум, Өвөрхангай аймаг,
УБД: 1014001028, E-mail: atsetserlegiilt@gmail.com

2020.07.10 № 31
танай 20.20.07.09-ны № 168 -Т

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Тус байгууллагын 2018, 2019 оны үйл ажиллагаа, үр дүнгийн хэрэгжилтэнд хийсэн аудитын тайлангын дүнг хүлээн зөвшөөрч байгаа болно. Аудитын тайланд тусгагдсан актыг заасан хугацаанд нь нийгмийн даатгалын хэлтсийн төвлөрсөн орлогод төвлөрүүлж, тайланд тусгагдсан албан шаардлагыг биелүүлэн зөрчилийг арилган ажиллана.

АРВАЙХЭЭР
ЦЭЦЭРЛЭГЖИЛТ
ОНӨААТҮГ
ЗАХИРАЛ

Д.МЯГМАР

\\Ajl-2020\\Alban toot A5-2020